

## Гадаад иргэдийн улсын эрүүл мэндийн даатгалд даатгуулах тогтолцооны талаар танилцуулж байна.

Таны гэр бүлд эрүүл энх, аз жаргалыг хүсэн ерөөе.

БНСУ нь 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн гадаадын иргэд болон гадаадад оршин суугч Солонгос иргэд 6 сар ба түүнээс дээш хугацаагаар Солонгос улсад түр оршин суух тохиолдолд, улсын эрүүл мэндийн даатгалд даатгуулж, эмнэлэг · эрүүл мэндийн байгууллагад үзлэг эмчилгээ хийлгэх тохиолдолд Солонгос иргэдтэй адилхан даатгалын тэтгэмжид хамрагдаж байна.

Гадаадын иргэд (гадаадад оршин суугч Солонгос иргэд) нь улсын эрүүл мэндийн даатгалын төлбөрийг сар бүрийн 25-ны өдөр хүртэл дараа сарын даатгалын төлбөрийг урьдчилан төлөх шаардлагатай. Таны төлсөн эрүүл мэндийн даатгалын төлбөр нь өвчтэй иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чухал санхүүжилт болдог бөгөөд эмнэлэг · эрүүл мэндийн байгууллагад төлөгддөг үзлэг эмчилгээний төлбөрөөр хэрэглэгддэг.

※ Одоогийн амьдарч буй хаяг тань өөрчлөгдөх тохиолдолд, улсын хилээр орж гарах асуудал эрхэлсэн газар эсвэл холбогдох хорооны төвд мэдэгдэх шаардлагатай бөгөөд, улсын эрүүл мэндийн даатгалын газар(гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн төв болон салбар)-т ч мөн адил заавал мэдэгдэх шаардлагатай.

### ■ Эрүүл мэндийн даатгалын төлбөрөө төлөөгүй тохиолдолд ■

- ① (Даатгалын тэтгэмжийн хязгаарлалт) Төлбөр төлөх хугацаа хамаарагдаж байгаа дараа сарын 1-ний өдрөөс эхлээд даатгалын төлбөрөө төлөх хүртэл эмнэлэг · эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэх тохиолдолд улсын эрүүл мэндийн даатгалын тэтгэмж хязгаарлагдана.
- ② (Виз сунгуулах зэрэг хязгаарлалт) Хууль зүйн яаманд виз сунгуулах зэрэг оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах тохиолдолд оршин суух хугацаа сунгахад хязгаарлалт тавих зэрэг хүндрэлүүд үүсэх магадлалтай.
- ③ (Төлөгдөөгүй төлбөр барагдуулах) Хугацаа тогтоон төлбөр төлөхийг шаардаж, тэрхүү хугацаа дуустал даатгалын төлбөрөө төлөөгүй тохиолдолд, үл хөдлөх хөрөнгө · автомашин · хадгаламж зэргийг битүүмжлэн албадан төлүүлэх арга хэмжээг авна.

Түүнчлэн, улсын эрүүл мэндийн даатгалын газар нь гар утас руу мессежээр даатгалын төлбөр төлөх аргачлал, тогтолцооны өөрчлөлт орсон байдлууд гэх зэргийг тогтмол мэдээлж байна. Та гар утасны дугаараа даатгалын газарт бүртгүүлэн төрөл бүрийн хэрэгтэй мэдээллүүдийг авна уу.

Надад зайлшгүй шаардлагатай мэдээллийг заавал нягталж үзээд хүсэлт гаргаарай.

- | Автомат шилжүүлгийн хүсэлт Төлбөр төлөгдөхгүй орхигдох зүйлгүйгээр даатгалын төлбөрөө хялбархан төлөх боломжтой.
- | Цахим нэхэмжлэлийн хүсэлт И-мэйлээр хялбархан төлбөрийн нэхэмжлэлтэйгээ танилцах боломжтой.
- | Буцаан олголт авах дансаа урьдчилан бүртгүүлэх хүсэлт Буцаан олголт үүсэх тохиолдолд бүртгүүлсэн данс руу тань шууд олгоно.

### Улсын эрүүл мэндийн даатгалын газрын дарга

☎ Үйлчлүүлэгчийн төв 1577-1000 / ☎ Гадаад хэл (Англи хэл, Хятад хэл, Вьетнам хэл)-ээр зөвөлгөө өгөх 033-811-2000